

**ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН  
ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ  
ЭСЭХ ТАЛААРХ ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 05 дугаар  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 21 гишүүнээс 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хүүхдийн оролцоонд суурилсан, хүүхдийн насанд тохирсон хөгжлийн үйл ажиллагаанд хүүхдийг тэгш хамруулах, багш, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх зэрэг олон асуудлыг шийдвэрлэх нэгдсэн зохицуулалт бүхий цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар хуулийн төсөлд заажээ. Хуулийн төслийг баталснаар Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжийг хэрэгжүүлэх тогтолцоо болон хүүхдийн хөгжлийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж, биеийн тамир, спорт, соёл урлаг зэрэг олон төрлөөр өөрийгөө хөгжүүлэх нь хүүхдийг бие даасан хувь хүн болж төлөвших, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэнэ гэж хууль санаачлагч үзсэн байна.

Хуулийн төсөлд хүүхдүүд өөрийн хүсэл сонирхлын хүрээнд оюун ухаан, бие бялдар, авьяас чадвар, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих хөтөлбөр, сургалт, дугуйланд хамрагдан ирээдүйн бие хүн болж төлөвшихөд нь төрөөс бодлогын болон санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх чиглэл, хэлбэр, арга зам, хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр төрийн байгууллагуудын чиг үүрэг, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны зарчим, үүрэг хариуцлага, хяналтын тогтолцоотой холбогдсон харилцааг зохицуулахаар тусгажээ.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалыг баримтлан Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдаж, 2026 оноос хэрэгжиж эхэлбэл Монгол Улсын 6-16 насны 800 мянга орчим хүүхдийн 1 сарын хичээлээс гадуурх сургалтын зардлыг дунджаар 50,000 төгрөг байхаар төлөвлөж 6 сарын хугацаанд хамрагдах 300,000 төгрөгийг төрийн зүгээс дэмжлэг үзүүлж, жилдээ 240 орчим тэрбум төгрөгийг Ирээдүйн өв сан болон Хуримтлалын сангаас зарцуулах шаардлага гарна гэж хууль санаачлагчид үзжээ.

Хуулийн төслийг [d.parliament.mn](http://d.parliament.mn) цахим хуудаст байршуулж иргэд, олон нийтийн санал авч байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцүүлэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр санхүүжилтийн эх үүсвэр, Үндэсний баялгийн сангийн оролцоо, “Хүүхдийн хөгжлийн төв”-ийн зохион байгуулалт, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах хуулийн хэрэгжилтийн бэлтгэл, барилга байгууламж, тоног төхөөрөмж, хүүхдийн хамрагдалт, сургуулийн орчинд хэрэгжүүлэх боломж, багшлах боловсон хүчний талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн хүүхдийн бие бялдар, сэтгэцийн эрүүл мэнд, хөдөлгөөний дутагдал, сэтгэл зүйн дэмжлэгийг хуульд хэрхэн тусгах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа санхүүжилтийн тогтолцоо, эрхийн бичиг, Ирээдүйн өв сангийн хөрөнгийг ашиглах боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын хүртээмж, сургуулийн орчин болон нийгмийн дэмжлэгийг хэрхэн сайжруулж, тэднийг тэгш хамруулан хөгжүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл сургалтын байр, багшлах боловсон хүчний талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр хөдөө сумын төвд байгаа хүүхдүүдийн хамрагдалтыг хэрхэн шийдэх талаар асуулт асууж, хариулт авсан.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр санхүүжилт, барилга байгууламжийн ашиглалт, эрхийн бичиг, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын хүртээмжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа Дорнод аймгийн хэмжээнд хэрэгжүүлж туршсан “Хүн болох багаасаа” төслийн үр дүнгийн тухай дурьдаж, хуулийн төслийг дэмжиж байгаа талаар тус тус үг хэлсэн болно.

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцогчдын олонх буюу 65.4 хувийн саналаар, хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 80.7 хувийн саналаар дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ,

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



П.ГАНЗОРИГ